

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 12 дугаар сарын 06

Мандалговь хот

№	Зорилт, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь
					Он	Түвшин			
2.5 Үндэсний бахархал, өв соёл									
2.5	<u>Зорилго:</u> Иргэдийг соёл гэгээрүүлэх, монгол өв соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо 2019 онд 294454 байсныг 2024 онд 37120-оор нэмэгдүүлнэ.	2021-2024	УТ 788.5	Соёл, урлагийн арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо	2022	313014	322294	Соёл, урлагийн байгууллагууд монгол өв соёл, соёл гэгээрүүлэх үйл ажиллагаа, урлаг уран бүтээлийн чиглэлээр нийт 43611 арга хэмжээ, сургалт сурталчилгааг зохион байгуулж, давхардсан тоогоор 370823 иргэн хамрагдлаа.	100
2.5.1	<u>Зорилт:</u> Соёл, урлагийн салбарын насжилт өндөртэй барилга байгууламжийн тоо 2020 онд 14 байгааг 2024 онд 64.2 хувиар бууруулна.	2021-2024	УТ 396.2	Тухайн жилд шинээр баригдаж буй барилгуудын гүйцэтгэлийн дундаж хувь	2022	70	80	Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч Хэрмээдэй ХХК нь төсөвт өртөг 1,523.4 сая төгрөг, тайлант хугацаанд 212,2 сая төгрөг зарцуулж, барилгын ажлын гүйцэтгэл 75 хувь, Дэлгэрцогт сумын Соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч ОДДА ХХК нь төсөвт өртөг 1,429.25 сая төгрөг, тайлант хугацаанд 131,5 сая төгрөг зарцуулж, гүйцэтгэл 90 хувь, гүйцэтгэлийн дундаж 82.5 хувьтай.	100
2.5.1.1	<u>Арга хэмжээ:</u> Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрын шинэ барилгын ажлыг үргэлжлүүлэх	2021-2024	УТ 70.0	Барилгын гүйцэтгэлийн хувь	2022	30	50	Соёлын яамнаас 2 удаа цахим хэлэлцүүлэг зохион байгуулагдсан. Хэлэлцүүлгээр барилгын ажлыг хуучин суурь дээр үргэлжлүүлэн барих, зураг төсвийг дахин шинэчлэн гаргахад	-

12

								шаардагдах хөрөнгө 250.0 сая төгрөгийн 50.0 сая төгрөгийг аймаг орон нутаг шийдвэрлэхээр, үлдсэн төсвийг сайдын багцаас шийдвэрлүүлэхээр хэлэлцлээ.	
2.5.1.3	<p><u>Арга хэмжээ:</u> Сумдын Соёлын төвийг стандартад нийцүүлэн хөгжүүлэх бодлого баримталж, Цагаандэлгэр, Өлзийт, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Баянжаргалан, Өндөршил, Адаацаг, Гурвансайхан, Дэлгэрхангай сумдын Соёлын төвийн барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах</p>	2021-2024	УТ 313.5	Шинээр баригдаж буй барилгуудын гүйцэтгэлийн дундаж хувь	2022	70	80	<p>Өлзийт сумын Соёлын төвийн барилга улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.2 тэр бум төгрөгөөр баригдаж 2021 онд ашиглалтад орсон. Гүйцэтгэл 100 хувь</p> <p>Эрдэнэдалай сумын Соёлын төвийн барилга улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.8 тэр бум төгрөгийн өртөг бүхий 400 хүний суудалтай шинэ барилга баригдаж 2021 онд ашиглалтад орлоо. Гүйцэтгэл 100</p> <p>Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч Хэрмээдэй ХХК Төсөвт өртөг 1,523.4 сая төгрөг, тайлант хугацаанд гүйцэтгэлээр 131.5 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон. 1, 2 давхрын дотор өрлөгийн ажил хийгдэж дууссан. Дотор засал, шаврын ажил эхлэх гэж байна. Барилгын ажлын гүйцэтгэл 75 хувь.</p> <p>Дэлгэрцогт сумын Соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч ОДДА ХХК нь төсөвт өртөг 1,429.25 сая төгрөг, тайлант хугацаанд 182.0 сая төгрөгийн санхүүжилт олгогсон. Барилгын өрлөгийн ажил дууссан. Гадна тохижилт, дотор заслын ажил хийгдэж, гүйцэтгэл 90 хувь.</p> <p>Баянжаргалан, Өндөршил, Дэлгэрхангай сумын Соёлын төвийн барилга 2024 оны Улсын төсвөөр хийгдэх хөрөнгө оруулалтын жагсаалтад тус бүр 2.8 тэр бум төгрөгийн төсөвт өртгөөр тусгагдсан.</p>	40.5

2.5.2	<p><u>Зорилт:</u> Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь 2020 онд 49.4 байгааг 2024 онд 51.7 хувьд хүргэнэ.</p>	2021-2024	УТ 37.0	Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь	2022	50	51.1	Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны батлагдсан орон тоо 138 үүнээс 2023 жилийн эцсийн байдлаар 72.5 хувь буюу 100 мэргэжлийн ажилтантай.	100
2.5.2.1	<p><u>Арга хэмжээ:</u> Соёл, урлагийн салбарын ажилтнуудыг гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцуулан, чадавхжуулах</p>	2021-2024	ОНТ 5.5	Гадаад, дотоодын сургалтад хамрагдсан ажилтны тоо /давхардсан тоогоор/	2022	250	300	<p>Мэргэжлийн боловсон хүчнийг нэмэгдүүлэх чиглэл өгснөөр СУИС-ийн харьяа Бадмаараг сургуулийн бүжгийн ангид 1, Сити дээд сургуулийн бүжгийн ангид 1, МУК-ын Бүжиг циркийн сургуулийн ардын бүжгийн ангид 5, Соёл урлагийн дээд сургуульд нэг өвийн ажилтан, Соёл урлагийн их сургуульд нэг хөгжмийн багш нийт 9 албан хаагч суралцаж байна. Мэргэжлийн их дээд сургуульд нийт 9 хүн суралцахаар элсэн орж, 7 суралцагчид "Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн зардлаас 722,0000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Нийт мэргэжилтэй ажилтны тоог 4-өөр нэмэгдүүлсэн. Мэргэжлийн чиглэлээр гадаадад 2 удаагийн сургалтад 19 соёлын ажилтан, улс болон аймаг орон нутгаас зохион байгуулагдсан цахим болон танхимын 75 төрлийн сургалтад 19, байгууллагын давхардсан тоогоор 525 албан хаагч хамруулж, мэдлэг ур чадварыг нь дээшлүүлэн чадавхжуулснаар ажлын бүтээмж дээшилж, олон улс, улсын хэмжээний арга хэмжээг чанартай сайн зохион байгуулсан.</p>	100

2.5.2.2	Арга хэмжээ: Соёл, урлагийн салбарын ажилтнуудыг орон сууцжуулах	2022-2024	ОНТ 10.0	Орон сууцанд орох хүсэлт гаргасан ажилтнуудын шийдвэрлэлтийн хувь	2022	50	70	Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн судалгаагаар нийт 175 ажилтан албан хаагчид ажиллаж байгаагийн 62 буюу 34 хувь орон сууцанд, түрээсийн байранд 16 буюу 8,8 хувь хашаа байшин, гэрт 104 буюу 57,1 хувь амьдарч байна. Байр, орон сууцанд орох 6 албан хаагчийн хүсэлт ирсний дагуу 4 сум 6 албан хаагчийг байгууллагын орон сууцанд оруулж, аймгийн "Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд нэг уран бүтээлчид байр орон сууцанд ороход 10 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Албан хаагчийг 100 хувь шийдвэрлэн орон сууцанд оруулснаар амьдрах таатай орчин бүрдэж, ажлын бүтээмжийг нэмэгдүүллээ.	100
2.5.3	Зорилт: Иргэдийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа 2019 онд 1431 байсныг 2024 онд 2587-д хүргэнэ.	2021-2024	ОНТ 839.5	Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны тоо	2022	2000	2298	Соёл, урлагийн салбарын 18 байгууллагаас цахим болон танхимын хэлбэрээр 2023 онд соён гэгээрүүлэх 2430 үйл ажиллагааг зохион байгуулж, 26189 иргэнийг хамруулснаар өмнөх оноос зохион байгуулсан үйл ажиллагааны тоо 606-аар өслөө.	100
2.5.3.1	Арга хэмжээ: Үндэсний бахархлыг шингээсэн шинэ уран бүтээлүүд туурвих	2021-2021	ОНТ 125.7	Шинээр туурвисан уран бүтээлийн тоо	2022	7	8	"Монгол түмнээ хүндлэн золгоё", "Эрхэмсэг", "Хоймор дүүрэн хийморь", "Эх түүхийг эргэцүүлэхүй", "Их хүндэтгэл", "Нар нь нүүдэллэсэн тэнгэрийн аялгуу, "Наран дуулал", "Их газрын чулуу", "Аниртай үдэш" 9 уран бүтээлийг шинээр болон шинэчилэн туурвиж, 370823 иргэнд соёлын үйлчилгээг хүргэснээр үйлчлүүлэгчдийн соёлын боловсрол дээшилж, үндэсний хэв шинжийг агуулсан урын сан баяжилт нэмэгдсэн.	100

		2021-2024	0,82 ОНТ	Тухайн жилд хүүхдэд зориулсан шинэ уран бүтээлийн тоо	2022	2	2	"Солгой харандаа", "Болдоггүй бор өвгөн", "Таягт" хүүхэлдэй жүжиг, "Жангарын 12 баатрын магтаал", "Миний хөөрхөн шүдний аялал" хүүхэлдэйн жүжиг, "Угалз" хамтлагийн өвөл цагийн нээлтийн тоглолт 5 удаа нийт 6 шинэ уран бүтээл найруулж, үзэгчийн хүртээл болгосноор нийт 3676 хүүхдийг соён гэгээрүүлж, чөлөөт цагийг нь зөв, үр ашигтай өнгөрүүллээ. Хүүхдийн уран бүтээлийн сан баяжигдаж, цаашид энэхүү уран бүтээлээрээ үйлчлэх, орлого олох нөхцөл бүрдсэн.	
2.5.3.2	Арга хэмжээ: Цэргийн ангийг түшиглэн "Үлээвэр хөгжмийн хамтлаг" байгуулах	2023	ОНТ 20.0	Хөгжмийн зэмсгийн хангалтын хувь	2022	0	100	"Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театрт байсан 20,000,000 төгрөгийн өртөг бүхий 10 төрлийн үлээвэр найрал хөгжмийн зэмсгийг Зэвсэгт хүчний 065-р ангийн 278-р байгууламжийн бие бүрэлдэхүүнд хүлээлгэн өгсөн.	50
				Үлээвэр хөгжмийн хамтлаг байгуулагдсан эсэх тийм-1, үгүй-0	2022	0	1	Үлээвэр хөгжмийн ангид 10 хүнийг Үндэсний батлан хамгаалахын сургуульд суралцуулахаар материалыг хүргэсэн бөгөөд шаардлага хангасан 5 хүнийг хөгжимчнөөр шийдвэр гарган, ажилд авлаа. Батлан хамгаалахын их сургуулийн Хөгжмийн сургуулийн мэргэжлийн багш нарыг урьж ирүүлэн, 21 хоногийн сургалт зохион байгуулахаар хэлэлцээр хийсэн.	
2.5.3.3	Арга хэмжээ: "Уяхан замбуу тивийн наран" уртын дуучид, морин хуурчдын наадмыг эвент зохион байгуулах	2023	ОНТ 15.0	Эвент наадмыг зохион байгуулсан эсэх тийм-1, үгүй-0	2019	1	1	"Уяхан замбуу тивийн наран" уртын дууч, морин хуурчдын их наадмыг байгалийн задгай театрт зохион байгуулж, нутгийн 55-аас дээш насны ахмад 1176, хүүхэд 706, 19-54 насны авьяастан 1218 нийтдээ 3100 авьяастанг сургаж, хамрууллаа. Улсын хэмжээнд хамгийн	100

								олон үзэгчтэй наадмаар тодорхойлогдож, 47 мянган иргэнд нутгийн үнэт өв соёлыг түгээн сурталчилж чадлаа.	
				Шавь сургалтаар бэлтгэсэн авьяастны тоо	2022	3000	3000	Шавь сургалтад морин хуурд-471, уртын дуунд- 2682 авьяастнууд бэлтгэгдэж, уртын дуу морин хуурын их наадамд амжилттай оролцлоо.	100
2.5.3.4	<u>Арга хэмжээ:</u> Дуу хуурын өлгий нутгийн алдартан, гавьяатнуудын хөдөлмөр бүтээлийг сурталчлан, алдаршуулах	2021-2024	УТ 192.9 ОНТ 105.1	Алдартан, гавьяатнуудын нэрэмжит болгон зохион байгуулсан арга хэмжээний тоо	2022	4	6	Аймгийн хэмжээнд "Уяхан замбуу тивийн наран" их наадам, Д.Данзанравжаагийн 220 жилийн ойн "Говийн бүсийн урлагийн их наадам", С.Буяннэмэхийн уран бүтээлийг сурталчлах, тэмдэгтэн шалгаруулах, Д.Дорждагвын нэрэмжит аймгийн хүүхдийн урлагийн наадам, МУГЖ Ж.Дүнжмаагийн удирдсан дугуйлангийн "Уран бүтээлийн тоглолт", "Соёлын сэргэлт" аян, яруу найрагч П.Нямлхагвын "Унаган туурай" тоглолт, улсын хэмжээний "Нүүдэлчин" Дэлхийн соёлын фестиваль, үндэсний их баяр наадмын үйл ажиллагаагаар нийт 9 арга хэмжээг зохион байгуулснаар нутгийн 38 СББӨ-ийн өвлөн уламжлагч, өв соёлыг олон нийтэд сурталчлан таниуллаа.	100
2.5.3.4.1	<u>Дэд арга хэмжээ:</u> Уран үгсийн чуулган яруу найргийн наадам зохион байгуулах		УТ ОНТ 10.0	Яруу найргийн наадамд оролцогчдын тоо	2022	30	50	"Уран үгсийн чуулган" яруу найргийн наадмыг нутгийн нэрт яруу найрагчид болон Дундговь аймгийн Утга зохиолын "Замбуу тив" нэгдлийн нийт 58 зохиолч, яруу найрагчид, сонирхогчид шүлэг яруу найргийнхаа дээжээс уншиж, уран үгсээр чууллаа.	100
2.5.3.5.1	<u>Дэд арга хэмжээ:</u> Музейн сан хөмрөгийг насжилт өндөртэй	2021-2024		Баяжуулсан үзмэрийн тоо	2022	21	29	1910 оны Дээд язгууртан эмэгтэйн гоо сайхны сав, алдартны хувцас, хэрэглэл, бичгийн хэрэглэл, хэрэглэж байсан эд	100

	эртний үзмэрүүдээр баяжуулах							зүйлс, Одоо хийгдэж байгаа гар урлалын зүйлсийг цуглуулга /эсгий, ноос, арьс, шир, модон урлал/, 1921-1980-аад оны үеийн айл гэрийн тавилга, Оёдол үйлийн багаж хэрэгсэл, оёдлын машин, зүү, утас, илүүр, индүү, үйлийн хайч, зах зээлийн дараа Монголд нэвтэрсэн, өргөн хэрэглээ болж байсан гадаад, дотоод орны хувцас, гутал ахуйн хэрэглээний эд зүйлс, Хөсөг, тээвэр, машин техник хэрэгсэл, Монголын аж ахуйн холбогдолтой эд зүйл зэрэг музей сан хөмрөгтөө 31 дэсийн 41 үзмэрийг хандив цуглуулгаар авч баяжууллаа.	
2.5.3.6	<u>Арга хэмжээ:</u> Сумдын түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг сумын гэрээт хамгаалагчтай болгох	2021-2024		Сумдын гэрээт хамгаалагчдын тоо	2022	30	30	15 сумын улс аймаг, орон нутгийн хамгаалалттай 408 дурсгалт газрыг 197 малчинтай сайн дурын гэрээ байгуулсан. Гэрээг хагас, бүтэн жилээр 2 удаа дүгнэн, гэрээгээ сайн биелүүлж ажилласан иргэнд жилийн турш урлаг, соёлын арга хэмжээнд үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрх олгож урамшуулсан. Үүний үр дүнд сумдын түүх соёлын үл хөдлөх дурсгалуудын хамгаалалт хамгаалалтад ямар нэгэн зөрчил гаргаагүй.	100
2.5.3.7	<u>Арга хэмжээ:</u> Төвд номын фондыг шинээр үүсгэн байгуулах	2021-2024	ОНТ 3.0	Баяжуулсан Төвд номын тоо	2022	50	185	Төв номын сан хандиваар 139 номын баяжилт хийн төвд номын фондыг шинээр үүсгэн байгуулсан бөгөөд Дашгэмпилэн хийдийн дэмжлэгээр номын тавиур, ховор судрын шоголыг хийлээ. Цахим катологи гаргах, хөрвүүлэг хийх ажлыг 2024 онд хийхээр төлөвлөсөн.	66
2.5.3.8	<u>Арга хэмжээ:</u> "Бүрдийн уянга" хүүхдийн зусланг	2021-2024	ОНТ 2.0	Тухайн жилд зохион	2022	4	4	Аймгийн Засаг даргын тамгын газар, Соёл, урлагийн газар, Тэнгэрийн	100

	түшиглэн "Ардын зан үйл-амьдрах ухаан" сургалтыг байгуулна. арга хөтөлбөрт зохион			байгуулсан сургалтын тоо				тэмдэг хүүхдийн театр, говийн бүсийн аймгуудтай хамтран Данзанравжаагийн 220 жилийн ойн хүрээнд "Говийн хүүхдүүд" урлагийн наадмыг зохион байгуулж, мөн 6 аймгийн хүүхдийн чуулганаар аймгийн Музейгээс "Ардын зан үйл амьдрах урлаг", "Монгол бичиг", тоглоом наадгай гэсэн 3 төрлөөр хөтөлбөрт сургалт, Төв номын сан "Дундговь аймгийн 9-н гайхамшиг", "Сүм хөх бүрд", "Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театраас морин хуур, уртын дууны сургалт, "Номын есөн өртөө" нийт 9 төрлийн сургалтыг зохион байгууллаа. Нэрт соён гэгээрүүлэгч Ноён хутагт Данзанравжаагийн уран бүтээл, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн үлдээх, хүүхэд багачуудад эх оронч үзэл, үндэсний өв соёлыг хайрлан хамгаалах ач холбогдлыг ойлгуулж, олон нийтэд сурталчлан таниулсан ажил боллоо.	
		2021-2024	ОНТ 1.0	Тухайн жилд хөтөлбөрт сургалтад хамрагдсан хүүхдийн тоо	2022	400	400	Бүрдийн уянга зуслан дээр зохион байгуулагдсан бүс, аймгийн хэмжээний сургалт үйл ажиллагаанд давхардсан тоогоор 6 аймгийн 499 хүүхэд хамрагдсан.	
2.5.3.9	<u>Арга хэмжээ:</u> Хэрэглэгчдийн эрх ашгийг дээдлэх "Ирээдүйн соёлтой үйлчлүүлэгч" төслийг сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулж, Монгол өв соёл, ардын	2021-2024	ОНТ 2.0	Зохион байгуулсан сургалтын тоо	2022	18	19	Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр, соёлын төвүүдэд уртын дуу, ардын дуу, морин хуур, ятга, ёочин, лимбэ, шанз, бөмбөр цохивор, утсан хөгжим, даралтат хөгжим, бүжиг, сур харваа, "Оюунлаг тархи", гийнгоо, зээ татах, шатар, даам, морь, бөх цоллох, утас ээрэх, ширдэг ширэх, дээс томох, зоос ширээний нэхмэл, зүү ороох, товч хадах, эсгий	93.3

уламжлалт урлагаа сурталчлан таниулна.							урлал, оньсон тоглоом, шагайн 4 төрөл наадгай, нийт 28 төрлийн сургалт зохион байгуулж, өв соёлоо сурталчлан, зааж сурган, ардын урлалын 16 бүтээл гаргалаа.
	2021-2024		Хамрагдсан хүүхдийн тоо	2022	3500	4500	Зохион байгуулсан сургалтад 3899 хүүхэд хамрагдсан байна
Хэрэгжилтийн дундаж хувь							91.1

ХЯНАСАН:
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА



Х.ЦОГЗОЛМАА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
УРЛАГ, УРАН БҮТЭЭЛИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Б.НАДМИДЦЭРЭН

